

**ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2024 оны 04 дүгээр
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Төсвийн байнгын хороо 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Элэг бүтэн Монгол” арга хэмжээг хэрэгжүүлэн гепатитын Д вирусийн халдвартай иргэдийг эмчилгээнд хамруулахаар тусгагдсаны дагуу уг вирусийн халдвартай иргэдэд шаардлагатай эмийн үнийг бууруулах, иргэдэд учрах санхүүгийн дарамтыг багасгах зорилгоор Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг боловсруулжээ.

Хууль батлагдсанаар гепатитын Д вирусийн халдвартай иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хүртээмж сайжирч, хүн амын өвчлөл, элэгний хатуурал, элэгний хорт хавдрын шалтгаант нас баралт, санхүүгийн дарамт буурахад эерэгээр нөлөөлнө гэж үзсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал “Элэг бүтэн Монгол” арга хэмжээнд тусгагдсан Д вирустэй тэмцэх үйл ажиллагааны хүрээнд баталсан төсвийн зарцуулалт болон энэхүү эм нь дэлхийн хэдэн улс орны эмчилгээнд ашиглагдаж байгаа үр дүнгийн талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Г.ТЭМҮҮЛЭН